



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/397

Мандалговь

Эзэмшил газрын нэр өөрчлөх тухай

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Шаргын хөшөөний зүүн талд Их тойруу 6-618 тоот), мөн 5 дугаар баг Хуучин НИК ШТС-ийн зүүн талд байршилтай "Дундговь аймгийн Улсын нөөцийн салбар"-ийн нэр нь өөрчлөгдөж "Онцгой байдлын газрын харъяа Дундговь аймаг дах Улсын нөөцийн газар" нэртэй болсон тул газрын гэрчилгээг шинэчлэн эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ГХБХБГазар, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2005 оны03 дугаар сарын 09-ний өдрийн 55 тоот захирамж, 2017 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А/362 тоот захирамжийн 1 дэх заалт Дундговь аймаг дах улсын нөөцийн салбарт холбогдох хэсэг, мөн газар эзэмших 000435672, 0009918 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200384